

Гүйцэтгэх захирлын 2022 оны
03 дугаар сарын 30-ны
өдрийн 1/23 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

АРИЛЖААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь "Хөдөө аж ахуйн бирж" ХХК (цаашид "Бирж" гэх) нь биржийн арилжаа зохион байгуулах болон түүнд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү харилцааг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулна.

1.3. Журмаар нарийвчлан зохицуулаагүй харилцааг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж бусад актад зааснаар зохицуулна.

1.4. Энэхүү журамд хэрэглэсэн "Биржийн систем", "Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх этгээд" гэх зэрэг нэр томъёо, ойлголтыг Биржийн үйл ажиллагааны Ерөнхий журам болон бусад журамд зааснаар тайлбарлана.

1.5. Энэхүү журамд хэрэглэгдэх дараах "Нэр томъёо"-г дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.5.1. "Арилжаа зохион байгуулагч" гэж биржийн арилжаа хөтлөх эрх бүхий этгээдийг;

1.5.2. "Арилжаа хянагч" гэж арилжааг холбогдох журмын дагуу зохион байгуулагдаж буйг хянах үүрэг бүхий этгээдийг;

1.5.3. "Байнгын гишүүн" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч (брокер)-ийн тусгай зөвшөөрлийн эрх авсан мөн биржийн "Гишүүнчлэлийн журам"-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан этгээдийг;

1.5.4. "Байнгын бус гишүүн" (хоршоо) гэж Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу арилжаанд оролцох зөвшөөрлийг Биржээс авсан, Гишүүнчлэлийн журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан этгээдийг;

Хоёр. Биржийн арилжааны төрөл, хэлбэр

2.1. Биржийн арилжааны төрөл, хэлбэр нь Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу байна.

Гурав. Биржийн арилжаанд оролцогч, тэдгээрийн эрх үүрэг

3.1. Биржийн арилжаанд байнгын гишүүн брокер болон байнгын бус гишүүн хоршоо оролцоно.

3.2. Биржийн арилжаанд оролцогч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

3.2.1. Биржийн арилжааны системд "авах", "зарах" захиалга оруулах, өөрийн захиалгын нөхцөлийг өөрчлөх, цуцлах зэрэг биржийн системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийх;

3.2.2. Танхимын арилжаанд оролцогч нь сүлжээний найдвартай байдал, программ хангамжаар хангуулах;

3.2.3. Биелсэн захиалгын жагсаалтыг биржийн системээр дамжуулан авч болох бөгөөд шаардлагатай тохиолдолд арилжаа хөтлөгчөөс хэвлэмэл хэлбэрээр авах;



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн "Арилжааны журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар, "Клиринг, төлбөр тооцооны журам"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэгдэн батлагдсан журмуудыг биржийн ажилтан, харилцагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэлтсийн менежер нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсан холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/15 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг, 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн А/12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг, 2019 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн А/03 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Р.Ариунбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.НАРАНДЭЛГЭР

3.2.4 Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т зааснаар биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолтыг гаргуулж авах.

3.3 Биржийн арилжаанд оролцогч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.3.1 Арилжаанд оролцогч нь биржийн холбогдох дүрэм, журам болон арилжаа хөтлөгчийн зааварчилгаа, шаардлагыг дагаж мөрдөх;

3.3.2 Арилжааны үед биржийн системд зөвшөөрөгдсөн үйлдлийг хийх явцдаа бусад оролцогчдод саад болох аливаа үйлдэл гаргахгүй байх;

3.3.3 Цахим арилжаанд оролцогч нь арилжаанд оролцох тоног төхөөрөмж, сүлжээний бэлэн байдлыг өөрийн зүгээс хангах;

3.3.4 Арилжаанд оролцогч нь биржийн системд нэвтрэх нэр болон нууц үгийг бусдад шилжүүлэхгүй байх;

3.3.5 Арилжаанд оролцогч нь арилжааны танхимын техник хэрэгсэл, программ хангамжийг зориулалтын бус зорилгоор ашиглахгүй байх.

Дөрөв. Арилжаа зохион байгуулах этгээд

4.1. Арилжааг арилжаа зохион байгуулагч удирдан зохион байгуулж, холбогдох журмын дагуу зохион байгуулагдаж буй эсэхэд арилжаа хянагч хяналт тавьж, танхимын арилжаанд оролцогчдын техник хэрэгсэл, программ хангамж, сүлжээний найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчигээ үзүүлэх үүргийг мэдээлэл технологийг хариуцсан этгээд тус тус хариуцан ажиллана.

4.2. Арилжааны үед арилжаа зохион байгуулагч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.2.1. Биржийн арилжааг ил тод, шударгаар явуулах, хараат бус байх;

4.2.2. Арилжааны бэлтгэл ажлыг хангах;

4.2.3. Арилжааг нээх, хаах, цуцлах;

4.2.4. Арилжааны явцад программ хангамжийн болон бусад аливаа саатал гарвал хариуцсан хэлтсийн менежер болон холбогдох этгээдэд яаралтай мэдэгдэж арга хэмжээ авах;

4.2.5. Цахим арилжааны хувьд арилжаа хөтлөгч цагийн хуваарийн дагуу эхлэх, дуусах мөчийг оролцогчид цахим хэлбэрээр, танхимын арилжааны хувьд цанг тус бүр нэг удаа цохиж мэдэгдэх;

4.1 Арилжааны үед арилжааны хянагч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

4.1.1 Арилжааны хянагч нь Хяналтын журамд заасан эрх, үүргийн хүрээнд арилжаанд хяналт тавих;

4.1.2 Арилжаанд оролцогч нь холбогдох дүрэм, журмыг зөрчсөн нь тогтоогдвол өөрийн эрх мэдлийн хүрээнд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.1.3 Арилжааны явцад техникийн болон программ хангамжийн аливаа саатал гарвал энэ тухай саатал эхэлсэн болон дууссан цаг минутаар тэмдэглэл хөтлөх, мэдээллэх.

Тав. Арилжаа зохион байгуулах

Арилжааны хэлбэр

5.1 Бирж арилжааг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

5.1.1 Цахим арилжаа;

5.1.2 Танхимын арилжаа.

Арилжааны үе, цагийн хуваарь

5.2 Арилжаа нь арилжааны бэлтгэл үе, үндсэн үе, хаалтын үе гэсэн 3 үетэй байна.

5.3 Биржээс амралтын өдөр хэмээн тодорхойлноос бусад буюу Даваа-

Баасан гаригуудад арилжаа явагдана.

5.3.1 Бэлтгэл үед арилжаа зохион байгуулагч нь биржийн системийн бэлэн байдлыг шалгаж, захиалгыг бүртгэж эхэлнэ. Арилжаа зохион байгуулагч нь өмнөх арилжааны өдөр системд орсон захиалгыг өөрчилж, эсхүл цуцалж болно.

5.3.2 Үндсэн үед энэ журмын 5.3.1-т заасан аргачлалаар үнэ тогтох ба, зах зээлийн захиалга, нөхцөлт захиалга болон биржийн системд зөвшөөрсөн бусад захиалгыг зөвшөөрнө.

5.3.3 Хаалтын үед зах зээлийн захиалга, нөхцөлт захиалга, кросс захиалгуудыг зөвшөөрнө. Хаалтын ханшийг тухайн өдрийн арилжааны тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшаар (Volume weighted average price буюу VWAP) тооцоолно.

Гэрээний үнэ тооцох

5.4 Биржээр арилжиж буй гэрээний үнийг тооцохдоо биржийн гэрээний тодорхойлолтод заасан аргачлалыг ашиглана. Гэрээний стандарт нөхцөл дараах аргаас аль нэгийг заасан байна. Үүнд:

5.4.1 **Дуудлага худалдаа:** Арилжаанд олон худалдагч, олон худалдан авагч оролцох ба арилжааны үед нэг үнэ тогтож, тухайн үнийг хүлээн зөвшөөрсөн захиалгууд биелнэ. Энэ аргын хувьд хамгийн их хэмжээ бүхий гэрээнүүд арилжаалах боломжтой үнийг сонгох зарчмыг баримтална.

5.4.2 **Үргэлжилсэн арилжаа/худалдаа:** Арилжааны үеийн турш хамгийн сайн үнийн санал бүхий захиалгууд биелнэ. Энэ аргын хувьд эхэлж оруулсан захиалга эхэнд биелэх зарчмыг баримтална.

5.4.3 **Англи дуудлага худалдаа:** Арилжаанд нэг худалдагч, олон худалдан авагч оролцоно. Зарах тал зарах доод үнээ барааны хэмжээтэй хамт өгөх ба хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелнэ. Үнэ хугацаа гэсэн дарааллыг мөрдөж, төлбөр тооцоог захиалгад өгсөн үнийн саналаар гүйцэтгэнэ.

5.4.4 **Нэг багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа:** Арилжаанд нэг багц барааг зарах нэг худалдагч, олон худалдан авагч орлоно. Зарах тал зарах доод үнээ өгөх ба хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелнэ. Үнэ хугацаа гэсэн дарааллыг мөрдөж, төлбөр тооцоог захиалгад өгсөн хоёр дахь сайн үнийн саналаар гүйцэтгэнэ.

5.4.5 **Олон багц бараан дахь хоёр дахь үнийн дуудлага худалдаа:** Арилжаанд олон багц барааг зарах нэг худалдагч, олон худалдан авагч оролцоно. Зарах тал зарах доод үнэ, хэмжээгээ өгч, авах тал авах үнэ, хэмжээгээ оруулна. Хамгийн сайн үнийн санал өгсөн захиалгууд биелэх ба үнэ хугацаа гэсэн дарааллыг мөрдөнө. Төлбөр тооцоог биелсэн захиалгуудын хамгийн бага үнийн саналаар гүйцэтгэнэ.

Үнийн хязгаарлалт

5.5 Бирж арилжааны үед тогтох үнийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх зорилгоор жишиг үнийг тогтооно.

5.5.1 **Жишиг үнэ:** Зэрэгцээ зах зээлийн үнэ, гадаад зах зээлийн үнэ, валютын ханшны өөрчлөлт, сүүлийн 20 арилжааны арифметик дундаж, өмнөх өдрийн биржийн жишиг үнэ зэргийг ашиглан EWMA аргачлалаар тооцоолно.

5.5.2 **Үнийн хэлбэлзэл:** Тухайн гэрээний арилжааны үнэд жишиг үнээс дээш доош тодорхой хувиар үнийн хязгаарлалтыг хийх ба хязгаарлалтын хэмжээг "Биржийн гэрээний тодорхойлолт"-д заана.

Арилжааг түр зогсоох

5.6 Бирж арилжааны үед үнийн өөрчлөлт "Биржийн гэрээний тодорхойлолт"-д заасан хязгаарлалтаас хэтэрсэн, техникийн саатал болон

давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол арилжааг түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хааж болно.

5.7 Биржийн гэрээний үнэд санаатайгаар дангаар болон бусадтай үгсэн хуйвалдаж нөлөөлөх сэжиг бүхий захиалга бүртгэгдсэн тохиолдолд тухайн захиалгуудыг цуцлах, арилжааг нийтэд нь түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хааж болно.

5.8 Бирж нь энэ журмын 5.5, 5.6-д заасан үндэслэлээр арилжааг түр зогсоож, эсвэл хугацаанаас нь өмнө хаасны дараа өмнө нь хийгдсэн захиалга болон хэлцлүүдийг хэсэгчлэн болон нийтэд нь хүчингүй болгож болно.

Зургаа. Захиалгын бүртгэл

Захиалгын төрөл

6.1 Арилжаанд оролцогч дараах захиалгуудыг оруулна. Үүнд:

6.1.1 Зах зээлийн захиалга: Тухайн үеийн зах зээлийн хамгийн сайн үнээр шууд биелэх ба захиалгыг биелүүлэхдээ захиалга оруулсан хугацааны эрэмбийг мөрдөнө.

6.1.2 Нөхцөлт захиалга: Захиалгыг оруулсан үнээс сайн үнээр биелүүлэх ба үнэ, хугацаа гэсэн эрэмбийг мөрдөнө.

6.1.3 Кросс захиалга: Талууд урьдаас хэлэлцэн тохиролцсон арилжааны захиалга.

6.1.3.1 Кросс захиалгаар талууд тухайн хэлцлийг хийх бараа түүхий эдийн үнэ, жин, тоо хэмжээ зэрэг мэдээллийг урьдаас хоорондоо тохиролцсоны үндсэн дээр хэлцэл хийгдэнэ.

6.1.3.2 Кросс захиалга нь тухайн захиалгад тусгагдсан үнээр хийгдэх бөгөөд үнийн хэлбэлзэл нь энэхүү журмын 6.4.2-т зааснаас хэтрэхгүй байна.

Захиалгын эрэмбэ

6.2 Арилжаанд оролцогчийн оруулсан захиалга нь арилжааны системд бүртгэгдсэн хугацааны эрэмбээр дугаарлагдан, захиалгын бүртгэлийн санд хадгалагдана.

6.3 Захиалга биелэх дараалал дараах эрэмбээр явагдана.

6.3.1 **Үнийн эрэмбэ:** өндөр үнээр худалдан авах, бага үнээр зарах захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.

6.3.2 **Цаг хугацааны эрэмбэ:** захиалгын үнийн ижил төвшинд захиалга биелэгдэх нөхцөл бүрдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд оруулсан захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.

Нэмэлт нөхцөл

6.4 Арилжаанд оролцогч нь энэ журмын 6.1.1, 6.1.2-т заасан захиалгууд дээр дараах нэмэлт нөхцөлүүдийг оруулж болно. Үүнд:

6.4.1 Оролцогч биелэх хэмжээтэй боломжоор дараах нөхцөлүүдийг оруулж болно.

6.4.1.1 Хэсэгчлэн биелэх захиалгын доод хэмжээг заах

6.4.1.2 Хэсэгчлэн биелсэн захиалгын биелээгүй үлдсэн захиалгыг цуцлах

6.5 Арилжаанд оролцогч арилжааны захиалгын хүчинтэй байх хугацааг заасан дараах нөхцөлүүдийг оруулж болно. Үүнд:

6.5.1 Тухайн агшинд хүчинтэй: Тухайн агшинд үнэ бодогдоход биелээгүй бол цуцална.

6.5.2 Арилжааны үед хүчинтэй: Тухайн арилжааны үеийн эцэст

цуцлагдана.

6.5.3 Өдрийн турш хүчинтэй: Тухайн өдрийн арилжааны эцэст цуцлагдана.

6.5.4 Заасан хугацаанд хүчинтэй: Тухайн заасан хугацааны эцэст цуцлагдана.

6.5.5 Цуцлах хүртэл хүчинтэй: Тухайн захиалга цуцлагдах хүртэл эсвэл хуанлийн 90 хоногт цуцлагдана.

6.6 Захиалгын нөхцөлийг сонгоогүй тохиолдолд арилжааны системд тохируулсан нөхцөлөөр бүртгэгдэнэ.

6.7 Арилжааны үед арилжаанд оролцогч захиалгыг оруулсны дараа захиалга биелээгүй эсвэл хэсэгчлэн биелж, биелээгүй үлдсэн захиалга байвал оролцогч захиалгыг өөрчлөх эсвэл цуцалж болно.

6.8 Арилжаанд оролцогч захиалгын нэмэлт нөхцөлд өөрчлөлт оруулсан тохиолдолд захиалгын эрэмбэ өөрчлөгдөхгүй бөгөөд бусад бүх өөрчлөлтөд захиалгыг өөрчлөлт хийсэн үеийн хугацаагаар эрэмбэлнэ.

Долоо. Арилжааны мэдээ

7.1 Биржийн арилжааны мэдээг өдөр, долоо хоног, сар, улирал жилээр, биржийн үнийн индексийг арилжааны өдөр бүр бодож энэ журмын 8.4-т заасан сувгаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ. Биржийн мэдээнд гэрээний нэр, үнэ, хэмжээ, хугацааг тусгасан байна.

7.2 Биржийн арилжааны үнийн индексийг холбогдох журам, тушаалын дагуу тогтоосон аргачлалаар тооцно.

7.3 Төрийн байгууллага болон биржийн гишүүн байгууллагуудад шаардлагатай мэдээг агуулга, хүргэх хэлбэр, давтамжийг харилцан тохиролцсоны үндсэн дээр хүргүүлнэ. Биржийн Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр эрх бүхий байгууллагаас шаардсан мэдээг гаргаж өгч болно.

7.4 Арилжааны мэдээг төрлөөс шалтгаалан дараах хэлбэрээр мэдээлнэ.
Үүнд:

- 7.4.1 Биржийн албан ёсны цахим хуудас;
- 7.4.2 Танхимын дэлгэц;
- 7.4.3 Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл;
- 7.4.4 Цахим шуудан;
- 7.4.5 Хэвлэмэл хэлбэрээр.

7.5 Биржийн мэдээллийг хуулийн этгээд албан хэрэгцээндээ тогтмол хэрэглэх хүсэлт тавьсан тохиолдолд энэ харилцааг 2 талын харилцан байгуулсан гэрээгээр зохицуулж болно.

7.6 Биржийн арилжааны мэдээ, тайлан болон статистик тоо, баримт нь биржийн өмчид хамаарна.

Найм. Хариуцлага

8.1 Арилжаанд оролцогч энэ журмыг зөрчсөн, эсвэл дараах хориглосон заалтыг зөрчсөн тохиолдолд Хяналтын журам болон бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хариуцлага хүлээнэ. Үүнд:

8.1.1 Харилцагчийн захиалгын цаг хугацааны дараалалд өөрчлөлт оруулсан, захиалгын маягтын дагуу зөв бүртгүүлээгүй;

8.1.2 Биржийн гэрээний үнэд санаатайгаар дангаар болон бусадтай үгсэн хуйвалдах замаар нөлөөлөхийг оролдох (манипуляци);

8.1.3 Бусад оролцогчийг төөрөлдүүлэх, худал мэдээлэл тараах;

8.1.4 Арилжааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулах.

8.2 Арилжаанд оролцогч энэ журам болон арилжаатай холбоотой аливаа эрх зүйн баримт бичгийг мэдээгүй, эсвэл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх

үндэслэл болохгүй.

Ес. Бусад

9.1 Гэнэтийн үйл явдал: Журмуудад тусгагдаагүй арилжаатай холбоотой гэнэтийн үйл явдал үүссэн тохиолдолд бирж шийдвэрлэх эрхтэй. Уг шийдвэр нь эцсийнх байх ба бүх талууд дагаж мөрдөнө.

9.2 Гүйцэтгэх удирдлага өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс хуанлийн 7 хоногийн өмнө нийтэд мэдэгдэнэ.

9.3 Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд дагуу холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

9.4 Энэхүү журмыг зөрчсөн, биелүүлээгүй бол Хяналтын журам болон Биржийн үйл ажиллагааны ерөнхий журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

__оОо__

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖЭЭР АРИЛЖСАН БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн /цаашид "Биржийн тухай хууль" гэх/ 4 дүгээр зүйлийн 4.5-д заасан экспортод гаргах биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг "Хөдөө аж ахуйн бирж" ХХК (цаашид "Бирж" гэх)-аар арилжсаныг нотлох тодорхойлолт олгохтой холбоотой тодорхойлолтын хүсэлт хүлээн авах, тодорхойлолтыг олгох, дахин олгох, хүчингүй болгох, тодорхойлолтын маягт захиалж хэвлүүлэх, бүртгэх, хадгалах, архивт хүлээлгэн өгөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Биржийн арилжаагаар худалдан авсан бараа, түүхий эдийг экспортлох тохиолдолд хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт (цаашид "Тодорхойлолт" гэх)-ыг олгоно. Тодорхойлолтыг тодорхойлолт хүсэгчийн гаргасан хүсэлтийн дагуу өөрт нь, эсхүл Биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасны дагуу Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

1.3 Тодорхойлолтын маягт нь компанийн үнэт цаас бөгөөд энэхүү маягтыг үнэт цаас хэвлэх магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий хэвлэлийн компаниар хэвлүүлнэ.

1.4 Энэхүү журамд хэрэглэгдэх дараах "Нэр томъёо"-г дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.4.1 "Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх этгээд" гэдэг нь ажлын байрны тодорхойлолт эсвэл Гүйцэтгэх захирлаас хариуцуулсан тодорхойлолт олгох үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий этгээдийг;

1.4.2 "Биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт" гэдэг нь биржээр арилжсан бараа, түүхий эдийн ангилал, нэр төрөл, боловсруулалт, хэмжээ, үнийн дүнг илэрхийлсэн биржийн албан ёсны лавлагааг;

1.4.3 "Биржийн систем" гэдэг нь Арилжаа, төлбөр тооцооны системийг;

1.4.4 "Тодорхойлолт хүсэгч" гэдэг нь биржийн арилжаанд худалдан авах тал болон оролцсон хуулийн этгээд, харилцагч этгээдийг;

1.4.5 "Тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд" гэдэг нь ажлын байрны тодорхойлолт эсвэл Гүйцэтгэх захирлаас хариуцуулсан этгээдийг;

1.4.6 "Тодорхойлолтын хураамж" гэдэг нь биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтын үнэ болон үйлчилгээний хөлсийг ойлгоно.

Хоёр. Тодорхойлолтын маягтыг бүртгэх, хадгалах, архивлах

2.1. Батлагдсан загварын дагуу хэвлэгдсэн бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтыг хүлээн авах, бүртгэх чиг үүргийг нярав, нягтлан бодогч, хадгалах чиг үүргийг архив хариуцсан ажилтан хариуцна.

2.2. Тодорхойлолтын бүртгэлийн дугаар нь биржийн систем дэх бүртгэлийн дугаартай ижил байна.

2.3. Тодорхойлолтын маягтыг нярав тусгай дугаарлагчаар дугаарлаж, тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээдэд хүлээлгэн өгнө. Тодорхойлолт олгох

чиг үүрэг бүхий этгээд зарцуулсан тодорхойлолтын маягтын тооцоог сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 05-ны өдрийн дотор нягтлан бодогчтой тооцоо хийнэ.

2.4. Тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд алдаатай бичигдсэн, засвар орсон, хугацаа хэтэрсэн болон бусад шалтгааны улмаас буцаасан тодорхойлолтыг хүчингүй болгож, эх хувиар нь санхүүгийн тооцоо нийлсэн тайланд хавсарган нягтлан бодогчид өгнө.

2.5. Тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд олгосон тодорхойлолтын хуулбар хувь, хяналтын картыг нэгтгэн хадгалж, Архивын журамд заасны дагуу компанийн архивт шилжүүлнэ.

Гурав. Тодорхойлолт олгох

3.1 Тодорхойлолтыг нь биржээр бараа, түүхий эд арилжсан харилцагчийн хүсэлтээр олгоно. Тодорхойлолт хүсэгч нь хүсэлтээ цахим хаяг (info@mce.mn)-аар болон цаасан хэлбэрээр гаргана.

3.2 Цахимаар ирүүлсэн тодорхойлолтын хүсэгчийн хүсэлтэд цахимаар хариу өгч шийдвэрлэж болно.

3.3 Тодорхойлолтын хүсэлтийг Арилжаа хариуцсан хэлтэст гаргах бөгөөд тодорхойлолт олгох үндэслэлтэй эсэхийг тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд Гүйцэтгэх захиралд танилцуулснаар, тодорхойлолтыг олгоно. Гүйцэтгэх захирал тодорхойлолтыг гарын үсэг, тэмдгээрээ баталгаажуулна. Гүйцэтгэх захирлын эзгүйд Дэд захирал, эсхүл Гүйцэтгэх захирлын тушаалаар эрх олгосон этгээд гарын үсэг зурна.

3.4 Тодорхойлолт олгоход тодорхойлолтын хураамж төлсөн баримт, хяналтын картыг үндэслэсэн байвал зохино. Шаардлагатай тохиолдолд биржээс эрх бүхий этгээд нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийх эрхтэй.

3.5 Тодорхойлолтод бараа, түүхий эдийн нэр төрөл, ангилал, боловсруулалт, хэмжээ болон үнийн мэдээллийг тусгах ба биржийн арилжааны биелсэн хэлцлийн мэдээг үндэслэн бичилт хийнэ.

3.6 Тодорхойлолтыг бараа, түүхий эдийг худалдан авсан хуулийн этгээд, харилцагч байгууллагын нэр дээр олгоно. Тодорхойлолтыг ажлын өдөр олгох ба тодорхойлолтын хүсэлт хүлээн авсны дараа олгоно. Самнасан ноолуураас бусад бараа түүхий эдийн тодорхойлолтыг өдөрт нь олгож болно.

3.7 Тодорхойлолтын үнэн зөвийг тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд хариуцна.

3.8 Тодорхойлолт бүр хяналтын карттай байх бөгөөд хяналтын картад Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх этгээд, Арилжаа хариуцсан хэлтсийн менежер гарын үсгээр баталгаажуулна. Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх этгээд нь цахимаар хяналт тавьж ажиллана.

3.9 Тодорхойлолт нь олгосон өдрөөс хойш ажлын 10 (Арав) хоногийн хугацаанд хүчинтэй байна.

3.10 Биржээр арилжсан боловсруулаагүй бараа, түүхий эдийн ангилал өөрчлөн тодорхойлолт олгохдоо боловсруулсан бараа, түүхий эдийн ангилалд хөрвүүлж, дараах хувиар шилжүүлж гарцын хэмжээг тооцно. Үүнд:

№	Барааны нэр	Хувь
1	Ноолуур	
	1 Боловсруулаагүй	1
	2 Угаасан	0.7
	3 Самнасан	0.5

2	Тэмээний ноос		
	1	Боловсруулаагүй	1
	2	Угаасан	0.7
	3	Самнасан	0.4
3	Хонины ноос		
	1	Боловсруулаагүй	1
	2	Угаасан	0.6
	3	Самнасан	0.4

3.11 Тодорхойлолт хүсэгч нь хүсэлт гаргасан өдрөө (яаралтай) тодорхойлолт авах бол хураамж болох 10000 (Арван мянга) төгрөгийг, бусад тохиолдолд 5000 (Таван мянга) төгрөгийг төлнө.

3.12 Энэхүү журмын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан шалтгаанаар тодорхойлолтыг дахин авах тохиолдолд 10000 (Арван мянга) төгрөгийг төлнө.

3.13 Тодорхойлолтын хураамжийг биржийн дансанд шилжүүлж болох ба бэлнээр төлөх тохиолдолд биржийн няравт тушаана.

3.14 Нярав нь тодорхойлолтын хураамжийн бэлэн мөнгөний тайланг гаргаж, нягтлан бодогчид тайлагнана.

3.15 Тодорхойлолтыг тухайн онд багтааж бүрэн олгосон байвал зохих бөгөөд он дамнаж тодорхойлолт олгохыг хориглоно.

Дөрөв. Тодорхойлолт хүчингүй болгох, дахин олгох

4.1 Бирж нь бараа, түүхий эдийн тодорхойлолтод заасан хугацаа хэтрүүлсэн, ашиглах боломжгүй болсон (урагдсан, гэмтсэн г.м) тохиолдолд Гүйцэтгэх захиралд хүсэлт гаргаж, дахин олгох эсэхийг шийдвэрлүүлнэ.

4.2 Бирж нь тодорхойлолт хүсэгчийн ашиглах боломжгүй болсон тодорхойлолтын хувийг Гаалийн байгууллагад цахим шуудангаар илгээж, тухайн дугаартай тодорхойлолт хүчингүй болсныг мэдэгдэнэ.

4.3 Хүчинтэй хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон тодорхойлолтын эх хувийг тодорхойлолт олгох чиг үүрэг бүхий этгээд нь буцаан хураан авч, бүртгэн, санхүүгийн тооцоо нийлсэн тайланд хавсарган санхүүд хүлээлгэн өгнө.

4.4 Энэ журмын 4.3-т заасан тодорхойлолтыг эх хувиар нь санхүүгийн баримтад хавсарган Архивийн журмын дагуу архивийн ажилтанд хүлээлгэн өгнө.

Тав. Хариуцлага

5.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журамд дагуу холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

5.2 Энэхүү журмыг зөрчсөн, биелүүлээгүй бол Хяналтын журам болон Биржийн үйл ажиллагааны ерөнхий журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

КЛИРИНГ, ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /цаашид “Бирж” гэх/-ийн төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, биржийн гэрээний клиринг, төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү харилцааг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Банкны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулна.

1.3 Журмаар нарийвчлан зохицуулаагүй харилцааг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж бусад актад зааснаар зохицуулна.

1.4 Энэхүү журамд заасан чиг үүргийг биржийн клиринг, төлбөр тооцоо хариуцсан хэлтэс гүйцэтгэх бөгөөд төлбөр тооцоо, клирингийн үйл ажиллагаанд төлбөрийг түргэн шуурхай, алдаагүй гүйцэтгэх, эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх, цахим системд тулгуурласан байх зарчмуудыг мөрдөж ажиллана.

1.5 Энэхүү журмын хавсралт нь журмын салшгүй хэсэг болно.

Хоёр. Клиринг, төлбөр тооцоонд оролцогч

2.1 Биржийн төлбөр тооцоонд дараах этгээд оролцоно. Үүнд:

2.1.1 Биржийн арилжаанд оролцогч байнгын болон байнгын бус гишүүн;

2.1.2 Харилцагч;

2.1.3 Төлбөр гүйцэтгэгч банк.

2.2 Биржийн арилжаанд оролцогч нь энэхүү журмын 1.2-т заасан холбогдох хууль тогтоомж, энэ журам болон биржтэй байгуулсан гэрээний эрх үүргээ мөрдөж ажиллана.

2.3 Биржийн арилжаанд оролцогч нь гишүүнчлэлийн гэрээгээр клирингийн эрхийг авснаар “Клирингийн гишүүн” болно.

2.4 Харилцагч гэж биржийн байнгын гишүүн оролцогчтой зуучлалын гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

2.5 Төлбөр гүйцэтгэгч банк (цаашид “Банк” гэх) гэж Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг хангасан, үйл ажиллагаа нь тогтвортой явагдаж буй биржтэй хамтран ажиллах тусгай нөхцөл бүхий гэрээ байгуулсан арилжааны банкиг хэлнэ.

2.6 Банк нь биржийн арилжааны дараах төлбөр тооцоог хийж гүйцэтгэх, тэдгээрийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой “Клирингийн данс¹” болон “Төлбөр тооцооны данс”-ыг нээж, гүйлгээг найдвартай, түргэн шуурхай гүйцэтгэх үндсэн чиг үүргийн дагуу ажиллана.

¹ Арилжаанд оролцогчийн дэнчин болон барьцаа хоронгийг төвлөрүүлэх данс.

Гурав. Клирингийн үйл ажиллагаа

3.1 Бирж нь төлбөр тооцооны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, арилжааны дараах төлбөр тооцоог худалдах, худалдан авах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ийн дагуу хийж гүйцэтгэх зэрэг клирингийн үйл ажиллагааг зохион байгуулна.

3.2 Биржийн арилжааны зах зээлд оролцогч нь гэрээтэй холбоотой төлбөр тооцоог клирингийн эрхтэй байнгын гишүүнээр гүйцэтгүүлж болно.

3.3 Биржийн гэрээний хэлцлийн бүртгэл, төлбөр тооцоо, дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээг арилжаа, төлбөр тооцооны систем (цаашид "биржийн систем" гэх)-д цахим горимоор, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэнэ.

3.4 Бирж нь клиринг, төлбөр тооцооны тайлан, банкаар хийгдсэн гүйлгээний журналыг 7 хоног бүр хөтөлж, сар, улирлаар нэгтгэн гаргана.

3.5 Төлбөр тооцоо хариуцсан хэлтэс нь гишүүн болон харилцагчийн мэдээллийн санг үүсгэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг шаардаж болно.

3.6 Бирж нь гишүүн болон харилцагчдаас ирүүлсэн санал гомдол, хүсэлтийг хүлээн авах, түүнийг шийдвэрлэх, тайлбар өгөх үүрэгтэй.

Дөрөв. Эрсдэлийн удирдлага

4.1 Биржийн арилжаанд оролцогчид төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой аливаа эрсдэлээс хамгаалах, түүний хэрэгжилт, баталгааг хангах зорилгоор дараах эх үүсвэрийг клирингийн дансанд төвлөрүүлнэ. Үүнд:

4.1.1 Дэнчин;

4.1.2 Барьцаа.

4.2 Дэнчин, барьцааг энэхүү журмын Хавсралт 1-д заасан хуваарийн дагуу клирингийн дансанд байршуулна.

4.3 Арилжаанд оролцогч гишүүнчлэлийн (клирингийн эрхтэй) гэрээ байгуулж, энэ журамд заасан барьцаа хөрөнгийг клирингийн дансанд байршуулсан тохиолдолд уг гэрээний эрх, үүргээс татгалзах, бусдад шилжүүлэхтэй холбоотой гарах зардал, шимтгэлийг өөрөө хариуцна.

4.4 Дараах тохиолдолд клирингийн данснаас хөрөнгө албадан шилжүүлнэ. Үүнд:

4.4.1 Холбогдох журамд заасан хугацаанд гэрээний төлбөр төлөгдөөгүй тохиолдолд хэлцлийн нөгөө талын арилжааны шимтгэл, үнийн зөрүү²-ний алдагдлыг барагдуулах;

4.4.2 Биржийн арилжаа, төлбөр тооцооны шимтгэл, хураамжийг холбогдох журмын дагуу төлж, барагдуулаагүй.

Дэнчин

4.5 Арилжаанд оролцогч энэхүү журамд заасан дэнчинг клирингийн дансанд байршуулснаар арилжаанд орох эрх үүснэ.

4.6 Клирингийн дансанд байршуулсан дэнчинг арилжаа эхлэхээс 30 минутын өмнөх үеийн үлдэгдлээр тооцож биржийн системд оруулна.

4.7 Гүйцэтгэх захирал дэнчингийн хэмжээг тушаалаар баталгаажуулах бөгөөд өөрчлөгдсөн тохиолдолд энэ тухай мэдээллийг ажлын 5 өдрийн өмнө биржийн албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ.

4.8 Дэнчингийн хэмжээг тогтоохдоо түүний төрөл болон биржийн гэрээний тодорхойлолтод үндэслэн дараах аргачлалын аль тохирохыг ашиглана. Үүнд:

4.8.1. Тогтмол;

4.8.2. Var;

4.8.3. SPAN.

² Цуцлагдсан хэлцлийн үнэ болон дараа өдрийн жигнэсэн дундаж үнийн зөрүүг ойлгоно.

4.9 Дэнчин нь дараах төрөлтэй байна. Үүнд:

- 4.9.1 Баталгаат дэнчин;
- 4.9.2 Анхдагч дэнчин;
- 4.9.3 Тогтворт дэнчин;
- 4.9.4 Төлбөр тооцооны дэнчин;
- 4.9.5 Хүргэлтийн дэнчин.

4.10 Биржийн гишүүн арилжаанд оролцохтой холбоотой гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож баталгаат дэнчинг байршуулна.

4.11 Арилжаанд оролцогчийн хэлцэл баталгаажуулах, хэлцлийн нөгөө талыг эрсдэлээс хамгаалах зорилгоор нийт оролцогчид анхдагч дэнчин байршуулна.

4.12 Арилжаанд оролцогчийг түүний захиалгатай холбоотой аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор анхдагч дэнчингийн тодорхой хувийг тогтвортой дэнчинд тооцож, анхдагч дэнчин тогтвортой дэнчингийн хэмжээнд хүрсэн тохиолдолд арилжаанд оролцогчид биржийн системээр дамжуулан мэдэгдэнэ.

4.13 Мэдэгдэл хүлээн авсан арилжаанд оролцогч дараах үйлдлийг хийх боломжтой. Үүнд:

4.13.1 Дэнчингийн хэмжээг нэмэгдүүлж, биржийн гэрээний эрх, үүргийг хадгалах;

4.13.2 Биржийн гэрээний эрх үүргээс татгалзах, эсвэл бусдад шилжүүлэх.

4.14 Хүргэлттэй гэрээний хувьд бараа хүлээлцэх, төлбөр гүйцэтгэх үеийн эрсдэлээс хамгаалах зорилгоор төлбөр тооцооны дэнчинг авах талаас, хүргэлтийн дэнчинг зарах талаас байршуулна. Спот гэрээний хувьд анхдагч дэнчинг төлбөр тооцоо болон хүргэлтийн дэнчинд тооцож болно.

Барьцаа

4.15 Клирингийн эрхтэй байнгын гишүүн нь харилцагчийн болон өөрийн хэлцлийн төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор клирингийн дансанд барьцаа байршуулна.

4.16 Барьцаа хөрөнгийг клирингийн эрх бүхий гишүүн биржтэй байгуулсан гэрээний хугацаанд заавал байршуулах ба 150.0 сая төгрөгөөс багагүй дүнтэй байна. Барьцааны хэмжээг арилжаа эхлэхээс 30 минутын өмнөх үеийн үлдэгдлээр тооцно.

4.17 Клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа нь биржийн системд оруулсан өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн хэмжээнээс багагүй байна. Хэрэв клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа хөрөнгө өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн нийт дүнгээс бага байгаа тохиолдолд тухайн гишүүний оруулсан захиалгыг хүчингүйд тооцно.

4.18 Клирингийн эрхтэй байнгын гишүүний барьцаа хөрөнгө өөрийн болон харилцагчийн анхдагч дэнчингийн нийт дүнгээс бага байснаас шалтгаалан харилцагчийг хохироосон бол энэ журамд заасны дагуу хариуцлага тооцно.

Эрсдэлийн сан

4.19 Эрсдэлийн сан нь гишүүнчлэлийн гэрээ бүхий байнгын гишүүний төлбөрийн чадвар, санхүүгийн нөхцөл байдал ноцтой түвшинд хүрсэн тохиолдолд эрсдэлийг хаах зориулалттай сан байна.

4.20 Энэ журмын 4.19-д заасан санг Эрсдэлийн сангийн журмаар зохицуулна.

4.21 Энэ журмын 4.19-д заасан эрсдэлийг хаасан тохиолдолд байнгын гишүүн нь эрсдэлийн сангаас зарцуулсан хөрөнгийг нэн даруй үл маргах журмаар төлнө.

Тав. Хэлцэл

5.1 Биржийн системд тодорхойлсон, биржийн гэрээг худалдах, худалдан авах нөхцөл таарч, тулгалт хийгдсэн захиалгуудыг хэлцэл гэж ойлгоно.

Хэлцэл өөрчлөх

5.2 Арилжаанд оролцогч хэлцлийн нөхцөлд дараах өөрчлөлт оруулахаар хүсэлт ирүүлж болно. Үүнд:

5.2.1 Хэлцлийн төлбөр гүйцэтгэх өдрийг өөрчлөх;

5.2.2 Хэлцлийн төлбөрийг хэсэгчлэн төлөх хуваарь гаргах;

5.2.3 Хэлцлийн үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх.

5.3 Хэрэв хэлцлийн үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх бол хүсэлт гаргасан этгээд тухайн хэлцэлд харгалзах арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийг нэмж төлнө.

5.4 Арилжаанд оролцогч биет хүргэлтгүй биржийн гэрээг шилжүүлэх, хүлээн авах тухай хүсэлтээ биржийн системээр дамжуулан цахим хэлбэрээр гаргах ба Гүйцэтгэх захирал зөвшөөрсөн тохиолдолд гэрээг шилжүүлнэ.

5.5 Бирж хэлцлийн нөхцөлд өөрчлөлт оруулахаас татгалзсан бол хүсэлт ирүүлснээс хойш нэг цагийн дотор энэ тухай арилжаанд оролцогчид мэдэгдэнэ.

5.6 Энэхүү журмын 5.2.1-5.2.3-т заасан хэлцлийн нөхцөл өөрчилсөнтэй холбоотой үүсэх эрсдэлийг арилжаанд оролцогч хариуцна.

Хэлцэл баталгаажуулах

5.7 Арилжаанд оролцогч гэрээг байгуулснаар хэлцэл баталгаажуулсанд тооцно. Гэрээний загварыг энэхүү журмын хавсралтаар батална. /Хавсралт 2/

5.8 Арилжаанд оролцогч хэлцлийн жагсаалтыг үндэслэн гэрээг дараа өдрийн арилжаа эхлэхээс өмнө байгуулж, биржид нэг хувийг ирүүлнэ. Бирж зөвшөөрсөн тохиолдолд гэрээг цахим хэлбэрээр ирүүлж болно.

Фьючерс гэрээ баталгаажуулах

5.9 Биржийн фьючерс гэрээний тодорхойлолтод заасан хугацаанд гэрээг баталгаажуулж, хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг байршуулна. Хэрэв хүргэлтийн болон төлбөр тооцооны дэнчинг хугацаандаа байршуулаагүй бол гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцно.

5.10 Биет хүргэлттэй гэрээг хэвлэмэл хэлбэрээр үйлдэж, захиалга оруулсан арилжаанд оролцогч, эсвэл түүний итгэмжлэл бүхий этгээд гарын үсэг, тэмдгээр баталгаажуулж, биржид гэрээний нэг хувь хадгалагдана.

5.11 Биет хүргэлтгүй гэрээг биржийн систем ашиглан цахим хэлбэрээр баталгаажуулж болно.

Хэлцэл цуцлах

5.12 Дараах тохиолдолд хэлцлийг цуцалж болно. Үүнд:

5.12.1 Талууд харилцан зөвшилцсөн;

5.12.2 Шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хууль зөрчсөн хэлцэл хийсэн нь тогтоогдсон;

5.12.3 Арилжаанд оролцогчийн болгоомжгүй үйлдлээс шалтгаалан хэлцэл хийгдсэн нь тогтоогдсон;

5.12.4 Биржийн мэргэжилтний алдаанаас шалтгаалан хэлцэл хийгдсэн болох нь тогтоогдсон;

5.12.5 Хэлцлийн нэг тал хүсэлт гаргасан.

5.13 Хэрэв зарах талын бараа нь барааны тодорхойлолт заасан шаардлагад нийцээгүйгээс болж хэлцэл цуцлагдсан бол зарах тал, бусад үндэслэлээр энэ журмын 5.12.5-д заасны дагуу хэлцэл цуцлах бол хүсэлт гаргасан этгээд тухайн хэлцлийн 2 талын холбогдох шимтгэл, хураамжийг төлнө.

5.14 Хэрэв хэлцэл цуцлагдсан бол энэ тухай баримт үйлдэж хадгална. Арилжаанд оролцогчийн хэлцэл цуцлагдсан бол энэ нь арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

Зургаа. Төлбөр тооцоо

6.1 Дараах төрлийн төлбөр тооцоог гүйцэтгэнэ. Үүнд:

6.1.1 Дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээ;

6.1.2 М2М;

6.1.3 ХХАГ-ний төлбөр;

6.1.4 Бусад.

6.2 Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь захиалга биелсэн хэлцлийн үнэ байна. Биет хүргэлттэй фьючерс гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь тус гэрээнд тусгагдсан үнэ байна.

6.3 Төлбөр тооцоо гүйцэтгэх үнэ нь арилжаанд оролцогчдын хувьд заавал дагаж мөрдөх, биржийн гэрээний төлбөр тооцоонд ашиглагдах үнэ байна.

Дэнчин, барьцаа хөрөнгийн гүйлгээ

6.4 Арилжаанд оролцогч дэнчин, барьцаа хөрөнгийг биржийн клирингийн дансанд байршуулна.

6.5 Арилжаанд оролцогч биржийн гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн, биржид өр төлбөргүй бол дэнчин, барьцаа хөрөнгийг буцаан авах эрх үүснэ. Бирж нь Хавсралт 4-д заасан маягтын дагуу гаргасан биржийн гишүүний хүсэлтийг үндэслэн дэнчин, барьцаа хөрөнгийг буцаан шилжүүлнэ.

М2М

6.6 Бирж нь фьючерс гэрээ эзэмшигчийн ашиг, алдагдлыг арилжааны дараа өдөрт 1 удаа тооцоолох бөгөөд өдрийн эцэст буюу 16:00 цагаас хойш арилжаанд оролцогчийн анхдагч дэнчинг ашиг, алдагдлын зөрүүгээр нэмэгдүүлэх эсвэл бууруулах гүйлгээг хийж гүйцэтгэнэ.

6.7 Хэрвээ энэхүү журмын 4.12-т заасны дагуу анхдагч дэнчинг нэмж байршуулаагүй тохиолдолд 6.6-д заасан гүйлгээ хийгдэхгүй.

Гэрээний төлбөр

6.8 Гэрээний төлбөрийг арилжаанд оролцогчийн гэрээн дэх дүнгээр худалдан авагч талаас нэхэмжилнэ. /Хавсралт 3/

6.9 Гэрээний худалдан авагч тал энэ нэхэмжлэхэд заасан гэрээний дүнг бараа хүлээлцэхээс өмнө төлбөр тооцооны дансанд байршуулсан байна.

6.10 Бирж зарах талын ирүүлсэн бараа хүлээлцсэн баримт (Хавсралт 5)-д тусгасан дүн (цаашид "Төлбөр тооцооны дүн" гэх)-г худалдан авагч талын гэрээний төлбөр, биржийн төлбөр тооцооны дансанд орсон өдөр гэрээнд заасан дансанд шилжүүлнэ.

6.11 Бараа хүлээлцсэн баримтад заасан тоо, хэмжээ нь гэрээнд зааснаас биржийн гэрээний стандартад зөвшөөрсөн хэмжээгээр өөрчлөгдөж болно. Хэрэв төлбөр тооцооны дүн гэрээний дүнгээс их бол уг зөрүүг авах талын төлбөр тооцооны дэнчингээс суутгаж, энэ журамд заасны дагуу зарах талын дансанд шилжүүлнэ. Эсрэг тохиолдолд зөрүү дүнг авах талын данс руу буцааж шилжүүлнэ.

6.12 Клирингийн эрх бүхий байнгын гишүүн нь гэрээтэй холбоотой төлбөр тооцоог хийж гүйцэтгэхдээ гэрээнд заасан дүнгээр бэлэн бус шилжүүлэг хийж гүйцэтгэх бөгөөд баримтыг хавсарган гэрээний хамт биржид хүргүүлнэ.

Долоо. Төлбөр тооцоонд хориглох зүйлс, бусад

7.1 Спот гэрээний дэнчинг төлбөр тооцоонд ашиглахгүй.

7.2 Албан ёсны тэмдэглэлт болон нийтээр амрах өдрүүд төлбөр тооцоо гүйцэтгэх өдөрт хамаарахгүй.

7.3 Төлбөр тооцоог аливаа баримт бичгийн хуулбар хувийг үндэслэн хийхийг хориглоно.

7.4 Биржийн дэнчингийн болон төлбөр тооцооны дансанд андуурсан гүйлгээ хийгдсэн бол тухайн этгээдийн албан бичгээр биржид ирүүлсэн хүсэлтийг үндэслэн шилжүүлнэ.

Найм. Хариуцлага

8.1 Төлбөр тооцоо гүйцэтгэх үед аливаа зөрчил илэрвэл зөрчил гаргасан этгээдэд Гүйцэтгэх захирлын тушаалаар сануулах, арилжааны дансыг битүүмжлэх, баталгаат болон анхдагч дэнчингээс суутгах хүртэл арга хэмжээ авч болно.

8.2 Арилжаанд оролцогч энэ журам болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Хяналтын журам болон гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.3 Биржийн гишүүн оролцогч нь өөрийн болон харилцагч, гишүүдийнхээ нэрийн өмнөөс биржээр арилжсан гэрээний биелэлтийг бүрэн хариуцна.

8.4 Арилжаанд оролцогч энэ журам болон төлбөр тооцоотой холбоотой аливаа эрх зүйн баримт бичгийг мэдээгүй, эсхүл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.5 Арилжааны банкны үйл ажиллагааны буруугаас болж аливаа зөрчил илэрсэн бол бирж хариуцлага хүлээхгүй.